



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/544

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "в", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дугаар зүйлийн 41.2.2, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7<sup>1</sup>.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар албан даалгавар /Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах/-ыг хэрэгжүүлэх, коронавируст халдвар тархалтын үед иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 3 дугаар 60 айлын орон сууцны барилгын дулааны шугам сүлжээний засварт 16,0 сая, 48 айлын орон сууцны барилгын дулааны шугам сүлжээний засварт 14,0 сая, Чандмань сумын цэвэр усны шугам сүлжээний ажилд 27,0 сая төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнүүдэд зарцуулах 57 000 000 төгрөг /тавин долоон сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.11-д тусгагдсан "Зүүн хаалганы намагжилтыг багасгах ажил /Жаргалант сум, Цамбагарав, Рашаант, Наран баг"-н үлдэгдлээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Төсөл арга хэмжээний захиалагчийн техникийн хяналт хийж тайлагнахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/, Чандмань сумын Засаг дарга /З.Онолбаатар/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zah A/544 Kh  
10 27 19